



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 294

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4,3 дахь заалт, 2019 оны 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 149,281,696.13 (нэг зуун дөчин есөн сая хоёр зуун наян нэгэн мянга зургаан зуун ерэн зургаан төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий автомашин, механизмыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ч.Чинбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлын хэсэг томилж, холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Дуудлага худалдааны зарыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудсанд байршуулах;

2.3. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.4 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг батлагдсан маягтын дагуу гарган 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



0000545

Төрийн өмчийн бодлого, зохицуулалт
 2019 оны 07 дугаар сарын 29
 2019... дугаар тогтоол



"Дулааны гуравдугаар цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Автомашины марк, дугаар, зориулалт, үүр, арлын дугаар	Ашиглалт тад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Х...
Мерседес, ачааны шин, 13-30 УБН, 38, JA74L019474	2005-10-30	376000	59,682,000.00	59,682,000.00	0	0	
Human truck, 87-92 C521838PA02A, PED47H024246	2007-11-30	387000	28,843,746.00	28,843,746.00	0	0	
"И", ачааны шин, 01-14 УНЗ, LQ1708108, D677J026458	2010-03-30	366500	24,386,363.64	24,386,363.64	0	0	
вер №5	1994-01-01	305000	36,369,586.49	36,369,586.49	0	0	
Нийт дүн			149,281,696.13 (нэг зуун дөчин есөн сая хоёр зуун наян нэгэн мянга зургаан зуун ерэн зургаан төгрөг арван гурван мөнгө)	149,281,696.13 (нэг зуун дөчин есөн сая хоёр зуун наян нэгэн мянга зургаан зуун ерэн зургаан төгрөг арван гурван мөнгө)	-	-	1